

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 23 тоот тогтоолоор батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ СОНГУУЛЬТ АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Салбарын ҮЭ-ийн холбооны сонгуульт ажилтан болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудын нийгмийн хамгааллын тухай шийдвэрийг тухайн ажилтныг сонгосон бага хурал түүний Тэргүүлэгч, бүх гишүүдийн хурал буюу тэдгээрээс эрх олгосон тэргүүлэгчдийн хурлаас гаргаж холбогдох зардлыг өөрийн төсөвтөө тусган шийдвэрлэнэ.

Хоёр.Тэтгэмж, буцалтгүй тусламж

ҮЭ-ийн хороодын орон тооны дарга нар болон ажлын албаны ажилтнуудад доорхи тохиолдолд тэтгэмж олгоно.

2.1 Салбарын ҮЭ-ийн холбооны дарга болон орон тооны ҮЭ-ийн хороодын дарга нарын сонгуулийн хугацаа нь дуусгавар болж дахин сонгогдоогүй, ҮЭ-ийн эвлэл нь татан буугдсан, орон тоо хасагдсан, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, биеийн эрүүл мэндийн улмаас ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн олгоно.

2.2 ҮЭ-ийн холбооны ажлын албаны ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.3-т заасан үндэслэлээр болон өвчний учир ажлаасаа бүр мөсөн чөлөөлөгдсөн тохиолдолд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг Тэргүүлэгчийн хурлаар хэлэлцэж олгоно.

2.3 Хоёроос дээш хүүхэд нь их, дээд сургуульд суралцаж байгаа ҮЭ-ийн сонгуульт ажилтнуудад нэг хүүхдийн сургалтын жилийн төлбөрийг нэг удаа олгоно.

2.4 Төрсөн эцэг, эх, гэр бүлийн хүн /эхнэр, нөхөр, хүүхэд/ нас барсан тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно.

2.5 ҮЭ, хөдөлмөрийн харилцаа, хууль, эдийн засаг, удирдахуйн ухааны чиглэлээр их, дээд сургуульд суралцах мөн доктор, магистрын зэрэг хамгаалахаар суралцвал төлбөрийн 50 хувийн хөнгөлөлтийг нэг удаа олгоно.

2.6 Ажилтан хүндээр өвчилсөн болон мэс засал хийлгэж 30 хоногоос дээш хэвтэн эмчлүүлсэн бол 1.000.000 төгрөг олгоно.

2.7 Ажилтан нас барсан тохиолдолд тухайн ажилтны 3 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тусламж олгоно.

2.8 Гэр орон шатсан, байгалийн гамшигт өртсөн үед 1000.000 төгрөг олгоно.

2.9 Шинээр хүүхэдтэй болсон ажилтанд 200.000 төгрөгийн тусламж олгоно.

Гурав.Сонгуульт ажилтны эрхийн баталгаа

3.1 Сонгуульт ажилтныг албан үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас хамгаалах дор дурдсан арга хэмжээг ҮЭ-ийн байгууллага өөрөө буюу бусад байгууллагатай хамтарч авна.

3.1.1 хувийн бие хамгаалагч ажиллуулах

3.1.2 сонгуульт ажилтны тухай мэдээллийг нууцлах

3.1.3 хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, няцаалт өгөх

3.1.4 аюулгүй байранд түр байрлуулах

3.1.5 шүүхэд нэхэмжлэл гаргах

Дөрөв.Орон тооны бус сонгуультны талаар

4.1 Орон тооны бус ҮЭ-ийн хороодын дарга нар ҮЭ-ийн сонгуульт ажил гүйцэтгэсний нэмэгдэл хөлсний хэмжээг бүх гишүүдийн хурлаас тогтооно. Нэмэгдэл хөлс нь жилийн дундаж татварын орлогын 30 хувиас ихгүй байна.

4.2 ҮЭ-ийн орон тооны бус дарга хийж байгаад тэтгэвэрт гарсан бол ажилласан хугацаанаас нь хамааруулан ҮЭ-ийн хорооны даргаар сонгогдсон хурлын тогтоолыг үндэслэн доорх тэтгэмжийг олгоно. /тэргүүлэгчид хамаарахгүй/

4.2.1 4-8 жил ажилласан бол тухайн салбарын ХХДХ-ээр

4.2.2 9-16 жил ажилласан бол тухайн салбарын ХХДХ-ээг 1,5 дахин нэмэгдүүлж

4.2.3 17-20 жил ажилласан бол тухайн салбарын ХХДХ-ээг 2 дахин нэмэгдүүлж

4.2.4 21 дээш жил ажилласан бол тухайн салбарын ХХДХ-ээг 2,5 дахин нэмэгдүүлж бодож олгоно.

Жич: ҮЭ-ийн орон тооны бус сонгуульт ажлыг он удаан жил, онцгой сайн хийж гүйцэтгэсэн нөхцөлд тухайн сонгуультанд тэтгэмж олгох асуудлыг Тэргүүлэгчийн хурлаар шийдвэрлэж болно.

Тав.Шагнал урамшуулал

5.1 Ажилдаа идэвх санаачилга гаргаж үр бүтээлтэй ажилласан ҮЭ-ийн хороодын дарга, ажлын албаны ажилтнуудыг төр, засгийн шагналаар шагнуулахаар тодорхойлох, хүндэт дэвтэрт бичих, МҮЭ-ийн болон салбарын ҮЭ-ийн холбооны шагнал, мөнгөн шагналаар шагнах асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.

---oOo---